

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны дугаар сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем болон орон зайн өгөгдлийн мэдээллийн сангаас үзүүлэх үйлчилгээ, лавлагаа, мэдээлэл авах үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай

Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь :

1.Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем болон орон зайн өгөгдлийн мэдээллийн сангаас үзүүлэх үйлчилгээ, лавлагаа, мэдээлэл авах үйлчилгээний хөлсний хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хураамжийн хэмжээг тогтоох тухай /газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох, гэрчилгээг бусдад шилжүүлэх, гэрчилгээний хугацааг сунгуулахад төлөх хураамжийн хэмжээ/” Засгийн газрын 2003 оны 09 дүгээр сарын 17-ны 205 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэхүү тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын сайд, Засгийн
газрын хэрэг эрхлэх газрын дарга

Д.АМАРБАЯСГАЛАН

Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем болон орон зайн өгөгдлийн мэдээллийн сангаас үзүүлэх үйлчилгээ, лавлагаа, мэдээлэл авах үйлчилгээний хөлсний хэмжээ

№	Үйлчилгээний нэр	Үйлчилгээний хөлсний хэмжээ (төгрөг)
Нэг. Газрын кадастрын үйлчилгээ		
1.1	Газрын нэгж талбарын тодорхойлолт	3,000
1.2	Газрын нэгж талбарын кадастрын зураг	3,000
1.3	Газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ	3,000
1.4	Газар өмчлөх, эзэмших эрхийг барьцаалсан эсэх лавлагаа	1,500
1.5	Монгол Улсын иргэнд төрөөс нэг удаа үнэ төлбөргүй газар өмчлүүлсэн эсэх лавлагаа	1,500
1.6	Монгол Улсын иргэнд төрөөс нэг удаа үнэ төлбөргүй газар хамтран өмчлүүлсэн эсэх лавлагаа	1,500
1.7	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шүүхийн шийдвэрээр түдгэлзүүлсэн эсэх лавлагаа	1,500
1.8	Газрын нэгж талбарын дуудлага худалдааны анхны үнийн лавлагаа	1,500
1.9	Газрын нэгж талбарын суурь үнэлгээний лавлагаа	1,500
1.10	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон шийдвэрийн хуулбар	1,000
Хоёр. Газар зохион байгуулалтын үйлчилгээ		
2.1	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяаллын тодорхойлолт	2,500
Гурав. Суурь судалгаа мониторингийн үйлчилгээ		
3.1	Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны баталгаажсан дүгнэлт	2,500
3.2	Иргэн, хуулийн этгээдийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэсэн талаарх түүхчилсэн лавлагаа	2,500
3.3	Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлт баталгаажсан эсэх талаарх лавлагаа	1,500
3.4	Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны мэдэгдэх хуудас	1,000
Дөрөв. Геодези, зураг зүйн үйлчилгээ		
4.1	Геодезийн хэмжилт, зураглалын багаж эзэмшигчийн лавлагаа	2,500
4.2	Геодезийн хэмжилт, зураглалын багаж баталгаажилтын түүхчилсэн лавлагаа	2,500
4.3	Геодезийн хэмжилт, зураглалын багажны баталгаат хугацааны лавлагаа	1,500

Тав. Орон зайн өгөгдлийн үйлчилгээ					
5.1		Байрлал, өндрийн сүлжээний цэг		9,200	
5.2	Геодезийн тулгуур сүлжээ	Геодезийн цэг, тэмдэгтийн хувийн хэрэг		1-10 цэг	3,000
				11-50 цэг	4,500
				51-ээс дээш цэг	6,000
5.3		Гравиметрийн сүлжээний цэг		20,600	
5.4	Байр зүй	1:1 000-ны байр зүйн зураг		1га	7,600
				1 хуудас	44,000
5.5		1:25 000-ны байр зүйн зураг		1мян.км ²	200,000
				1 хуудас	20,000
5.6		1:100 000-ны байр зүйн зураг		1мян.км ²	50,000
				1 хуудас	5,000
5.7	Барилга, суурин газар		1га	5,000	
5.8	Өндөржилт		1мян.км ²	200,000	
			1 хуудас	20,000	
5.9	Газар ашиглалт		1мян.км ²	10,000	
5.10	Газрын бүрхэвч		1мян.км ²	20,000	
5.11	Газрын нэгж талбар		1га	5,000	
5.12	Дэд бүтэц		1га	5,000	
5.13	Ортофото зураг	Ортофото зураг		1мян.км ²	200,000
				1 хуудас	20,000
5.14	Ортофото зураг	Хиймэл дагуулын зураг	Боловсруулсан	1мян.км ²	20,000
			Түүхий	1мян.км ²	10,000
5.15	Геологи, орчин	1:3 000 000 болон түүнээс дээш масштаб		Улс	150,000
				Улс	1,000,000
		1:3 000 000 -аас 1:500 000 хүртлэх масштаб		Аймаг	200,000
				Сум	50,000
5.16	1:50 000 -аас 1:200 000 хүртлэх масштаб			150,000	
5.17	1:3 000 -аас 1:25 000 хүртлэх масштаб			200,000	
5.18	Хөрсний зураг		1мян.км ²	20,000	
5.19	Инженер геологийн цооногийн мэдээ		1 цооног	30,000	